

УДИРДЛАГЫН УХААНЫ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

MODERN TRENDS IN MANAGEMENT SCIENCE

**Ж.Баттөгөлдөр***Дотоод хэргийн их сургуулийн**Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч**Удирдсан багш: Ч.Чулуунхүү**Хилийн албаны сургуулийн**Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа*

Товч утга: Уг сэдвээр урьд өмнө нь хил судлалын магистр О.Баттулга “Хилийн тусгай ангийн захирагчийн удирдах ажиллагааг сайжруулах арга зам” Н.Бат-Итгэл “Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх арга зам”, Э.Майдар “Хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам”, К.Алтанбек “Хилийн цэргийн ангийн удирдах албан тушаалтны мэдлэг, чадвар албанд нөлөөлөх нь” зэрэг сэдвүүдээр магистрын ажил горилсон бүтээл бичиж байсан ба миний бичсэн энэхүү илтгэл “Удирдлагын ухааны орчин үеийн чиг хандлага” гэдэг үгийг тайлбарлах, одоогийн хил хамгаалах байгууллагын бүх шатны удирдлагын арга барил, чадвар чадамжийг дээшлүүлэх талаар үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Түлхүүр үгс: Удирдлага, чиг хандлага

Abstract: On this subject, master of border studies O. Battulga "How to improve the management of the head of the special border unit" N. Bat-Itgam "How to improve the leadership of the manager of the border protection organization" E. Mairdar wrote master's theses on topics such as "Ways to improve military professional management of the Border Guard Organization", K. Altanbek "Influencing the knowledge and skills of the border guard unit's senior officers", and this report I wrote The aim is to explain the term "modern trends in management science" and to give an assessment of the management methods and capabilities of all levels of the current border protection organization.

Keywords: Management and trends.

Цэргийг удирдана гэдэг нь юуны түрүүнд хүн хүнээ удирдахыг хэлнэ. Тийм болохоор цэргийг бат тууштай атлаа шуурхай, уян хатан

удирдах захирагчийн чадвар нь түүний хувийн зан төлөвөөр илэрч байдаг. Цэргийн дарга бол мэргэжлийн болон сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй, цагийн байдлын ямарч хүнд нөхцөлд тэвчээр алдахааргүй хатуужилтай, өөртөө хатуу шаардлага тавьж чаддаг, хариуцлагыг өөрөө үүрэхэд бэлэн байхын дээр хамгийн гол нь захирагсдадаа халамжтай, хүндэтгэлтэй ханддаг байх учиртай.

Шинжлэх ухаанд ерөнхий асуудлаас тодорхой руу шилжин судлах арга зүй байдаг. Энэ нь тухайн тодорхой асуудалд хандахдаа ерөнхий асуудлаа эхнээс нь зөв ойлгож, нэгдсэн тодорхой ойлголттой болох зайлшгүй шаардлагатай байдаг.

Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ¹⁵⁵. гэж Батлан хамгаалах хуульд тусгасан бөгөөд Хил хамгаалах байгууллага нь Монгол улсын төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог нь байгууллагын удирдан зохион байгуулахад удирдахуйн ухаанаас гадна, цэргийн удирдлагыг онолын талаас нь судалж, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Цэргийн удирдлага бол удирдлагын онцгой төрөл байдгийн учир нь байлдааны зэвсэг, тусгай зориулалтын техниктэй, түүнийгээ хуулийн дагуу хэрэглэх эрх бүхий төрийн цэргийн байгууллагуудыг удирддагт оршино.

Цэргийн удирдлагыг судлахын тулд нэр томъёоны ойлголтыг мэдэх нь чухал бөгөөд "Удирдлага" гэдэг ойлголтыг шинжлэх ухааны талаас нь ойлгох нь чухал юм. Монгол хэлний их тайлбар толь бичигт "Удирдлага гэдэг үг нь удирдах үйл ажиллагаа, удирдах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэгч, удирдамж буюу заавар өгөх"¹⁵⁶ гэсэн утгыг агуулсан байна.

Винер.Н.-ын "Удирдагч хүн" гэдэг номондоо удирдлагын тухай нэлээд өргөн хэмжээнд авч үзэж, "Удирдлага нь механик, биологийн болон нийгмийн системд байдаг хамгийн ерөнхий /өргөн хүрээтэй/ шинж чанар, харилцан ажиллагаа"¹⁵⁷ гэж тодорхойлсон бол зохион байгуулалт болон удирдлагын салбарын тэргүүний онолчдын нэг Питер Фердинанд Друкер "Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм" гэжээ.

¹⁵⁵ Батлан хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 9-р зүйл Төрийн мэдээлэл. 2016. №36

¹⁵⁶ Монгол хэлний их тайлбар толь бичиг. УБ 2015

¹⁵⁷ Н. Винер, Удирдагч хүн. УБ. 1998

XIX зууны сүүлчээр ОХУ-ын Цэргийн шинжлэх ухааны тайлбар тольд удирдлагын тухай анхны тайлбарыг хийж "Цэргийн удирдлага гэдэг нь олон тооны, янз бүрийн салбарыг нэгтгэн захирахаар байгуулагдсан тусгай байгууллага" гэж тодорхойлсон байна.

"Цэргийн удирдлага" гэдэг нэр томъёог бүх талаас нь бүрэн тодорхойлсон тодорхойлолт байхгүй боловч Шинжлэх ухааны ном, зохиолуудад "Цэргийг удирдах" гэдэг ойлголтыг "Цэргийн удирдлага" гэдэгтэй адилтган тайлбарлаж байгаа нь бүрэн оновчтой бус бөгөөд нэлээд өргөн ойлголт юм. Энэ бүгдээс үзэхэд "Удирдлага" гэдэг нэр томъёо нь хүмүүс объектууд болон ажиллагааны үйл явцад зориудаар, зорилго-чиглэлтэй нөлөөлж байгаа хүний үйл ажиллагааны нэг төрлийг хэлнэ.

Удирдагч хүн өөрийн гаргасан тушаалын хүрээнд болон түүнээс гадна хүмүүсээс хамаарч байдаг тул түүнд албан ёсны бүрэн эрхээс гадна эрх мэдэл хэрэгтэй. Энэ

талаар Джон Л.Коттер тэмдэглэхдээ "Удирдагч хүн эрх мэдлийг хөгжүүлэх шаардлагатай байдаг. Яагаад гэвэл нэгдүгээрт: удирдагч хүн захиргаандаа байдаг хүмүүсээс үргэлж хамаарч байдаг, хоёрдугаарт: орчин үеийн байгууллагад түүний гаргасан тушаал заавруудыг бараг хэн ч хүлээн авч бүрэн захирагддаггүй.

Удирдлага нь удирдагч, удирдуулагч хоёрын хооронд үүсэх нийгмийн харилцаа бөгөөд хамтын хөдөлмөр үүссэн үеэс удирдлага үүсжээ. Өөрөөр хэлбэл нэг хэсэг нь хийж нөгөө хэсэг нь хийлгэж ирсэн. Хүмүүсийн хамтын үйл ажиллагаанд удирдлагын тухай ойлголт ямагт байсаар ирсэн. Удирдлагын үйл ажиллагаа шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үнэлэлт өгөх үйл явцаас бүрдэнэ. Хүнийг удирдаж зална гэдэг үнэнхүү бэрх ажил бөгөөд чаддаг хүндээ урлаг, чадахгүй хүндээ дарамт болдог. Хүнийг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа урьд ч байсан, одоо ч байгаа, хойшид ч байх болно. Удирдах ажил бол ухамсарт үйл ажиллагаа бөгөөд менежментийн шинжлэх ухаанд тулгуурлана. Хүний сэтгэлийн "багш" байж, сэтгэл зүйн ухааныг ашиглаж хүний өөрийнх нь дотоод нөөц хүчийг илрүүлж чаддаг тийм байгууллага л үр дүнд хүрдэг явдал нотолгоо шаардахгүй үнэн болж хувирчээ. Хамт олны сэтгэл зүйн уур амьсгал, хувийн сонирхол, онцлог, удирдах ажилтны нэр хүнд, хүнтэй хамтран ажиллах чадвараас ажлын амжилт шалтгаалж байна. Тэр тусмаа менежерийн хүнтэй ажиллах чадвараас хамт олны доторх сэтгэл зүйн уур

амьсгал нэлээд шалтгаалдаг. Нийгэм эдийн засгийн хөгжлийг хэр зэрэг задлан шинжилж, оновчтой шийдвэр гарган хэрэгжүүлж байгаагаар нь тухайн улс орны шинжлэх ухаан, оюуны чадавхыг хэмжиж, удирдах ажилтны чадавхыг харж болно. Төрийн байгууллагын удирдах ажилтан хүн, хүнийг өөртөө татах дээд зэргийн чадварыг эзэмшсэн байхыг хаа хаанаа л номлодог. Хүнтэй хамтран ажиллах чадвар мөхөс удирдах ажилтан үүргээ биелүүлэхэд үлэмж бэрхтэй байдаг. Хүнтэй ажиллах урлаг төрөлхөөс заяадаггүй. Тэр нь сургалтын янз бүрийн хэлбэр амьдралын туршлага, өөрөө өөртэйгөө ажиллах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг буюу удирдах ур чадвар амьдралын туршид төлөвшдөг. Хүнийг, хүний сэтгэл зүйг танин мэдэх явдал удирдах ажилтны маш чухал чанар юм.

Удирдлагын системд хүмүүсийн оролцоо тэргүүлэх үүрэгтэй учраас зарчимч бүтээлч удирдагч тухайн системийн нэн чухал бүрэлдэхүүн байдаг. Удирдлагадаа өндөр итгэл хүлээлгэх, захирах, захирагдах ёсыг хатуу баримтлах нь цэргийн удирдлагын онцлог тал юм. Энэ нь захирагч бие бүрэлдэхүүнийхээ бүх талын өсөлт хөгжилтийг хөхүүлэн дэмжиж тэднээс хувийн сахилга батаа өндөрт авч явахыг шаардах, захирагдагсад нь түүний шаардлага, дэмжлэгийн хариуд үнэн сэтгэл гаргаж хөдөлмөрлөх зэргээр илэрч байдаг. Захирагдагсад өөрсдийн амлалт, үүргээ нээлттэй, мэдээлэлтэй байлгах нь удирдлагын нэг зорилго бөгөөд ажил, үүргийг эзэнгүйдүүлж, саланги, тусгай байдалд тэмүүлэх хандлагыг үл дэмжих нь захирагчийн эрхэлвбэл зохих нэг чанар юм.

Захирагч өөрийн үүрэг, тушаал, ажиллагааны тактикийг боловсруулахдаа хэрхэн гүйцэтгэхийг нарийвчлан тодорхойлох албагүй бөгөөд түүний хамгийн тэргүүний үүрэг бол захирагдагсдын бие даасан ажиллагаанд удирдамж болохуйц өөрийн бодлогыг тодорхой илэрхийлэх асуудал байдаг. Удирдлагын өөр нэг чухал үүрэг бол байгууллагын хэмжээнд итгэлцэх, ойлголцлыг бүрдүүлэхийн суурь болох баг, бүлгийн найрсаг, ойр дотно харилцааг төлөвшүүлэх асуудал юм. Захирагч хүн бие бүрэлдэхүүний итгэл, үнэмшил төгс ойлголцлын суурь болох хамт олны уламжлалт үнэт зүйлсийг хөхүүлэн дэмжиж ажиллах ёстой. Захирагч нь бие бүрэлдэхүүн санаачилгатай ажиллах, хамт олон дотроо учраа ололцоход бүх нийтээрээ дэмжлэг үзүүлэх уур амьсгал бий болгоход хүчтэй нөлөө үзүүлэгч байх ёстой.

Хүн удирдана гэж үндсэндээ хүний зүрх сэтгэлийг таньж мэдэх, түүнийг эзэмдэх ур чадвар юм. Өороор хэлбэл удирдах ажилтан хүн бусдын

зүрх сэтгэлийг таньж чаддаг ондор мэдрэмжтэй байх ёстой. “Биеийг нь хураах гэвэл сэтгэлийг нь тат, сэтгэлийг нь татвал бие нь хаа холдох вэ?” хэмээн Чингис хаан айлджээ. Хүний сэтгэлийг хураах хамгийн сайн эрдэм бол удирдаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгох. Үүний тулд хэлж буй бүхнийг нь сонсч, хүсч буй бүхнийг нь мэдэрч түүнд нийцүүлж шийдвэр гаргах явдал юм.

Хүнтэй ажиллах нь түүний ур чадвар бөгөөд удирдах ажилтны шинж чанарыг тодорхойлж байдаг. Тийм ажлын хэлбэр нь хамт олныг зохион байгуулах идэвхжүүлэх зарим тохиолдолд цаг үеэ олон шийтгэл, зэмлэлтэй хослуулахыг шаарддаг. Хүн гэдэг өөрөө байгалийн амьтан төдийгүй бас нийгмийн амьтан мөн. Иймээс хүний амьдралын мөн чамар түүний дотоод сэтгэлээр илэрч байдаг. Удирдах ажилтан хүний дотоод сэтгэлд дараах шинжүүд ямагт байх ёстой гэж үздэг. Үүнд:

- Удирдах ажилтан хүний хамгийн эрхэм чанар нь “Өөрийгөө бусдын төлөө зориулах явдал” өөрөөр хэлбэл өрөөлийн төлөө өөрийгөө залж зориулахад оршино. Энэ утгаараа удирдах ажилтан байна гэдэг “Өөрийгөө ялан гарах аугаа их сорилт болой”. Учир нь би гэхээсээ илүү тэд гэж бодож тэдний төлөө ухамсарт амьдралаа зориулах учиртай.
- Удирдах ажилтан хүн бусад хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн чанаруудыг өөртөө төлөвшүүлэх ёстой. Хүний олон талт үйл ажиллагаанаас илэрсэн “сайн талууд”-ын үндсэн дээр бий болсон итгэл хүндлэлийг нэр хүнд гэж ойлгодог. Нэр хүнд төлөвшин тогтох үндсэн зам нь тэрээр хамт олныхоо төлөө зүтгэх явдал юм. Алдар нэрийг олж авах хэцүү, олж аван хадгалах бүр хэцүү гэсэнчлэн удирдах ажилтан нэр төрөө ямагт хайрлах ёстой.
- Хүн удирдана гэж үндсэндээ хүний зүрх сэтгэлийг таньж мэдэх, түүнийг эзэмдэх ур чадвар юм. Өөрөөр хэлбэл удирдах ажилтан хүн бусдын зүрх сэтгэлийг таньж чаддаг ондор мэдрэмжтэй байх ёстой. “Биеийг нь хураах гэвэл сэтгэлийг нь тат, сэтгэлийг нь татвал бие нь хаа холдох вэ?” хэмээн Чингис хаан айлджээ. Хүний сэтгэлийг хураах хамгийн сайн эрдэм бол удирдаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгох. Үүний тулд хэлж буй бүхнийг нь сонсож, хүсч буй бүхнийг нь мэдэрч түүнд нийцүүлж шийдвэр гаргах явдал юм.
- Удирдах ажилтан хүний сэтгэл, сэтгэлгээ гэдэг үргэлж залуу, шинэлэг байх ёстой. Ийм ч учраас “Улиг домог болсон нэг хэвийн

зүйлсийг үгээрээ ч үйл ажлаараа ч тойрч бай” хэмээн эртний их сэтгэгч Пифагор айлджээ.

- Удирдах ажилтан хүний онцлог шинж нь түүний зарчимтай ажиллагаагаар тодорхойлогдоно. Иймээс жинхэнэ удирдагч хүн өөрийн гэсэн удирдахуйн философи, амьдралын зарчимтай байх ёстой Жишээ нь: Чингис хааны удирдахуйн гол философи нь “Хүчтэй байх явдал бөгөөд чамайг няц дарна, тэгээгүй цагт чи намайг няц дарна” Би юу? Чи юу? гэсэн зарчимд тулгуурлаж байжээ.

Дүгнэлт:

Цэргийн анги байгууллагууд нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагын тогтолцоо мөн учир “төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах” зарчимд тулгуурлах нь хэн бүхэнд ойлгомжтой боловч аливаа асуудлыг захиран тушаах журмаар биш аль болох хүн рүү чиглэсэн хүмүүнлэг аргаар шийдэхийг цаг ямагт анхаарах нь чухал болов. Гэхдээ шаардлагатай үед ямар ч үүргийг биелүүлэх чадварыг хадгалж байх нь цэргийн анги байгууллагын менежерүүдийн онцлог чанар байх ёстой. Үүний тулд цэргийн шинжлэх ухаан, хил судлалын шинжлэх ухааныг менежментийн шинжлэх ухаантай чадварлаг зов хослуулан ажиллах авьяасыг эзэмших шаардлагатай.

Цэргийн анги байгууллагын дунд шатны менежерүүдийн манлайлалыг дээшлүүлж тэдэнд алба салбарынхаа менежмент, ажлын стандартыг бие даан шинэ төвшинд хүргэх бололцоог аль болох олгох хэрэгтэй. Учир нь энэ түвшний менежерийн зорилтын цар хүрээ өргөн, үр дүнгийн хэмжүүр өндөр, хийж бүтээх ажил нь их байдаг. Менежментийг анги байгууллагадаа хэрэгжүүлж байгаа явц үндэслэн дэвшүүлж буй дээрх саналуудыг цогцолбор байдлаар хэрэгжүүлбэл орчин үеийн цэргийн анги байгууллагуудын менежмент шилдэг тэргүүний төдийгүй олон улсын жишиг, төвшинд хүрэх бололцоотой гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. “Хилийн тусгай ангийн захирагчийн удирдах ажиллагааг сайжруулах нь” 2014 он
2. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он
3. Батлан хамгаалах тухай хууль УБ., 2016 он

---o0o---